



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГИЙН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/531

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэхь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Булган сумын 5 дугаар баг, 16, 17, 208 дугаар орон сууцны айл өрхөд хэрэгцээний халуун усны шугам татах (Булган сум) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Баганадант” ХХК-тай 295 000 484 (хоёр зуун ерэн таван сая дөрвөн зуун наян дөрөв) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Баганадант” ХХК-ийн захирал (А.Нямжаргал)-д үүрэг болгосугай.

3. Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд хяналт тавихыг “Булган мээж” ОНӨХК (Г.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010897

Аймгийн Засаг даргын 2024 оны
07 дугаар сарын 23 ны өдрийн
А/531 дугаар захирамжийн хавсралт



№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	4 776 879	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	4 776 879	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	2 388 440	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	19 900 000	Ү.Бямбасүрэн
5	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 90 хоног	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Бумцэнд
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Бумцэнд Ү.Бямбасүрэн